

“Шарын гол”ХК – ийн үйл ажиллагаанд

Дотоод хяналт шалгалтыг зохион

байгуулах журам

2013 оны 12 – р сарын

1. Журмын зорилго

- 1.1 Дотоод хяналт шалгалтын ажил нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.
- 1.2 Дотоод хяналт шалгалтын зорилго нь “Шарын гол” ХК – ийн үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн болон борлуулж байгаа бараа, бүтээглэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээн хууль тогтоомжц, Ерөнхийлөгчийн зарилга, Засгийн газрын шийдвэрт нийцэж байгаа эсэхэд байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдалыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.
- 1.3 Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, компанийн үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.

2. Хамрах хүрээ

- 2.1 Эрүүл ахуйн шаардлага/ Ажлын байрны талбай, Агааржуулалт, гэрэлтүүлэг, ус хангамж, ажилчдын хоолны илчлэг, чанар аюулгүй байдал, ахуйн хангамж, амралтын өрөө, усанд орох газар, ажлын байрны эргономик, ажлын байрны орчин физик, химийн хүчин зүйл, ажилласдын эрүүл мэндэд хяналт тавих/
- 2.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа / хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын удирдлага, зохион байгуулалт, сургалт, машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, дараалтат сав, шугам хоолой, өргөх, зөөх, хэмжих хэрэгслийн туршилт баталгаажуулалт /
- 2.3 Экологийн аюулгүй байдал / Хог хаягдал, хөрс, усны бохирдол, нөхөн сэргээлт /
- 2.4 Ажил үйлчилгээний чанарт хяналт тавих / технологи, түүхий эд бүтээгдэхүүн, борлуулалт, түрээсийн үйл ажиллагаа/
- 2.5 Хэмжих хэрэгслийн нэгдмэл, баталгаат байдал хяналт тавих
- 2.6 Цахилгаан хангамж, цахилгаан тоног төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагаа

3. Чиглэл

- 3.1 “Шарын гол” ХК – ийн нүүрс олборлох борлуулах, хөрс хуулалт бусад уулын ажилтай холбоотой процес, объект, субъектүүдийн үйл ажиллагаа
- 3.2 Дотоодоо шинэ техник, технолги нэвтрүүлэх
- 3.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сахин хамгаалах

4. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

- 4.1 Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарилга, засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон ШГХК – н хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт.
- 4.2 Үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хяналт шалгалт хийх.
- 4.3 Үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт хяналт шалгалт хийх.
- 4.4 Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт шалгалт хийх.
- 4.5 Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт.
- 4.6 “ШГХК – ийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” – д тухайлсан заасан хяналт шалгалт.

5. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтан түүний эрх, үүрэг

- 5.1 ШГХК – ийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах үүргийг Гүйцэтгэх захиралын тушаалаар баталгаажуулан томилсон ажилтан /дотоод хяналт шалгалтын ажилтан/ гүйцэтгэнэ.
- 5.2 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь Гүйцэтгэх захиралын шууд удирдлаганд, зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.
- 5.3 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь байгуулагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшсэн, мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай хүн байна.
- 5.4 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харъялагдах нэгж, объектын тоог харгалzan тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан Гүйцэтгэх захиралаар батлуулан мөрдөж ажиллана.
- 5.5 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгжээс доошгүй удаа ШГХК – ийн хэсэг нэгжийн удирдлагуудад, ерөнхий мэргэжилтэнүүдийн хэмжээнд тайлагнаж, шаардлагатай бол Гүйцэтгэх захиралын тушаалаар гаргуулан нийт ажиллагсдад мэдээлнэ.
- 5.6 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь Гүйцэтгэх захиралаар батлуулсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.
- 5.7 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь дараах нийтлэг эрх үүрэгтэй байна.
 - 5.7.1 Дотоод хяналт шалгалт зохион байгуулах төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах
 - 5.7.2 Хяналт шалгалтыг явуулахдаа хэсэг нэгжийн удирдлагуудтай шууд харицаж, тэдгээрээс мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтаны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдалын талаар тайлбар гаргуулах
 - 5.7.3 Илэрсэн зөрчил, дутагдалын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчилийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах.
 - 5.7.4 Шаардлагатай бол илэрсэн зөрчил, гаргасан этгээдэд хариуцлага ноогдуулах талаар компанийн хэмжээнд сургалт зохион байгуулах
 - 5.7.5 Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөгөх

- 5.7.6 Холбогдох дүрэм журамд нийцүүлэн, байгууллагын стандарт боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах
- 5.7.7 Дотоод хяналт шалшалтын үр нөлөө болон мэргэжлийн чадвахыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгуулагаас мэргэжилт арга зүйн зөвлөгөө авах, зөрчилийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагуудад танилцуулах
- 5.7.8 Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчилийн талаарх мэдээллээр удирдлагыг хангах
- 5.7.9 Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж , мэдээллийн сан бүрдүүлэх
- 5.7.10 Дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллага болон удирдлагуудад мэдэгдэх

6. Хариуцлага

- 6.1 Дотоод хяналт шалгалтыг энэхүү журам болон холбогдох хууль, Засгийн газрын тогтоолын заалтын дагуу ажлаа гүйцэтгэхгүй тохиолдолд дотоод хяналтын ажилтанд хөдөлмөрийн тухай хууль ба компаний дотоод журамд заасан хариуцлагыг ноогдуулна.
- 6.2 Дотоод хяналтын ажилтан болон харилцах субъектүүдүн үйлдэл эс үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгуулагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 6.3 Дотоод хяналт шалгалт явуулж байгаа эрх бүхий албан тушаалтанд үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад учирнуулсан этгээдийг холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.